



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 01 дүгээр сарын 08  
№02 /1200/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠥᠷᠢᠢᠨ  
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡ

ᠲᠥᠷᠢᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡ

ᠲᠥᠷᠢᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡ

ᠲᠥᠷᠢᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡ

ᠲᠥᠷᠢᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡ



**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

06.	Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	26
07.	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	29
08.	Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	30
09.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	31
10.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	32

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

11.	Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай	33
-----	--	----

Дугаар 103

06'	Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	26
07'	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	29
08'	Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	30
09'	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	31
10'	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	32
11'	Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай	33



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар  
сарын 17-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.4, 6.5 дахь хэсэг нэмсүгэй:

#### **1/6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсэг:**

“6.4. Чөлөөт бүсийн үйл ажиллагааг нээх, түр хаах асуудлыг Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар шийдвэрлэнэ.

6.5. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагааг нээх, түр хаах асуудлыг энэ хуулийн 6.4-т зааснаас гадна хил залгаа улстай байгуулсан олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл бий болсон тохиолдолд дипломат шугамаар шийдвэрлэнэ.”

**2 дугаар зүйл.** Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн гарчгийн “тогтоох” гэсний дараа “, үйл ажиллагааг нээх, түр хаах” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Чөлөөт бүсийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт:**

“3.1.11. “эдийн засгийн хамтын ажиллагааны бүс” гэж хил залгаа улстай тус тусын хилийн зурвас дахь газарт Засгийн газар хоорондын хэлэлцээрт үндэслэн байгуулсан чөлөөт бүсийг.”

#### **2/6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг:**

“6.3. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу хил залгаа улстай эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулж болох бөгөөд уг чөлөөт бүсэд баримтлах бодлого, чиглэл, тэдгээрийг хил дамнансан байгууламжаар холбох асуудлыг холбогдох улстай байгуулсан гэрээгээр зохицуулна.”

#### **3/25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг:**

“25.3. Чөлөөт бүсэд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг цагдаа, дотоодын цэрэг гүйцэтгэнэ.”







## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

### КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “2021 оны 12 дугаар сарын 31-ний” гэснийг “2022 оны 06 дугаар сарын 30-ны” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

ЯКЖ НОЛӨГ 09 ДЬЛО) Т 60' [өөрөгчиг\* Т  
ИӨӨРӨГӨГ ӨЛӨГ 09

01 - 0 Өрө\* Өсү Өкжээ Дөдө10 Иөлдөг\* т

5 гөдөг\* 1011г Ө19 Нөөл 11 5055 Ө09 0 01 гөкж\* 2г\* т 119

» 5055 Ө09 0 0Ө гөдөг\* 2г\* т 119 30 - 0 » К10 Өөкжээс11өдөк11

18' 1 гөкж Кжээт 09 « 5051 Ө09 0 15 гөдөг\* 2г\* т 119 31 - 0 » К11жээс 1  
Өөкжээт 201К Иөлдөгчөөг 1 грөдөгчөөг Дөөг Нөөл 119 18 гөдөг\* 1011г 09  
Сг\* Дөөгөг Өсү гөлдөгчөөг 2гкжээт К\* Дөвсөж\* Иөлкж\* Өдг 09 1гсг( Д0  
1 гөкж\* 1011г | Өөмөт101200 Нөлдөгч 1 | Идгч - 1Д 1 - 119

Нөөл 00 Өөкжээс11өдөг Өөдөгчөөг Дөөг  
Өөкжээт 201К Иөлдөгчөөг 1 грөдөгчөөг Дөөг 1  
гөлдөгчөөг 2гкжээт К\* Дөвсөж\* Иөлкж\* Өдг 09 1гсг( Д0  
| Өөмөт101200 Нөлдөгч 1 | Идгч - 1Д 1 - 119 Сг\* Дөөгөг Өсү

Өөгчөөгчөөгчөөг\* Нөгс  
5051 Ө09 0 15 гөдөг\* 2г\* т 119 30 - 0 Өрө\*

ИӨӨРӨГӨГ ӨЛӨГ 09 Нөөл 11

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

## ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 27<sup>1</sup>.1.9 дэх заалт нэмсүгэй:

“27<sup>1</sup>.1.9.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлах.”

**2 дугаар зүйл.**Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “шилжүүлэх” гэсний дараа “, хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1</sup>.2 дахь хэсгийн “27<sup>1</sup>.1.1, 27<sup>1</sup>.1.2, 27<sup>1</sup>.1.3, 27<sup>1</sup>.1.4, 27<sup>1</sup>.1.5, 27<sup>1</sup>.1.6, 27<sup>1</sup>.1.7-д” гэснийг “27<sup>1</sup>.1.1, 27<sup>1</sup>.1.2, 27<sup>1</sup>.1.3, 27<sup>1</sup>.1.4, 27<sup>1</sup>.1.5, 27<sup>1</sup>.1.6, 27<sup>1</sup>.1.7, 27<sup>1</sup>.1.8-д” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

### Г.ЗАНДАНШАТАР

<p>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ</p> <p>2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр</p>	<p>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ</p> <p>2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр</p>	<p>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ</p> <p>2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр</p>	<p>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ</p> <p>2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр</p>
---	---	---	---



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 дугаар  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.2 дахь хэсгийн “38.1.6,” гэсний дараа “38.1.9,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“38.1.9.иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгсэл,”

Тайлбар: “Хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгсэл” гэж Монгол Улс 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-ийн хавсралтад заасан бүтээгдэхүүнийг ойлгоно.”

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

### Г.ЗАНДАНШАТАР

Ажлал, Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1  
Монгол Улс 09

Видео, 09 Дэл.0) Т

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

Ногоо, 09 Дэл.0) Т 60' [Бөгөөд 1

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА





**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.2 дахь хэсгийн “13.1.9,” гэсний өмнө “13.1.6,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“13.1.6.иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгсэл;”

Тайлбар: “Хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгсэл” гэж Монгол Улс 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-ийн хавсралтад заасан бүтээгдэхүүнийг ойлгоно.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

<p>Үндэсний хуульч нартай хамтран          2022 оны 01 сарын 20-ны өдөр          Говьсүмбэр дүүрэг</p>	<p>Хуульч нартай хамтран          2022 оны 01 сарын 20-ны өдөр          Говьсүмбэр дүүрэг</p>	<p>Хуульч нартай хамтран          2022 оны 01 сарын 20-ны өдөр          Говьсүмбэр дүүрэг</p>	<p>Хуульч нартай хамтран          2022 оны 01 сарын 20-ны өдөр          Говьсүмбэр дүүрэг</p>	<p>Хуульч нартай хамтран          2022 оны 01 сарын 20-ны өдөр          Говьсүмбэр дүүрэг</p>	<p>Хуульч нартай хамтран          2022 оны 01 сарын 20-ны өдөр          Говьсүмбэр дүүрэг</p>
--	---	---	---	---	---

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 103

Улаанбаатар  
хот

### **Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон Оюу толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагчтай хийсэн хэлэлцээрийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчаас ирүүлсэн саналыг харгалзаж дараах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй:

1/Оюу толгой төслийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн 34 хувь /Эрдэнэс Оюу Толгой ХХК/-д ногдох Оюу Толгой ХХК-иас Туркойс Хилл Ресурсес Лтд-д төлөгдөх 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хуримтлагдаад байгаа нийт 2.3 тэрбум ам.долларын ерийг 100 хувь тэглэх;

2/Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Оюу Толгой ХХК болон Туркойс Хилл Ресурсес Лтд, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд, Оюу Толгой ХХК-ийн хооронд 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө”-г хуульд нийцүүлэн цуцалж, хүчингүй болгох;

3/Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх;

4/Оюу толгой төслийн гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас жил хүртэлх нэмэлт зардлыг гадаадын хөрөнгө оруулагч тал 100 хувь хариуцаж, Эрдэнэс Оюу Толгой ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх, Оюу Толгой ХХК-д хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдээс нэмэлт зээлийн санхүүжилт авахгүй байх;

5/Оюу Толгой ХХК-ийн засаглалыг сайжруулах, Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс цахилгаан эрчим хүчээр







**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

**Индекс: 200003**